



ҮАГ, ҮАГ-ын харьяа ГАА-ийн Аудитын газрын 2015 оны
бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний
дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

**“УУЛ УУРХАЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ХӨРӨНГИЙН
ТӨВЛӨРҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ ҮР ДҮН”**



АУДИТЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

**БАТАЛГААНЫ МӨНГӨН ХӨРӨНГИЙГ ИЛҮҮ ДУТУУ ТӨВЛӨРҮҮЛЖ, ЗОРИУЛАЛТ
БУСААР ЗАРЦУУЛСАН НЬ ОРОН НУТГИЙН УДИРДЛАГА, ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ
ЭЗЭМШИГЧ НЬ ХУУЛИАР ХҮЛЭЭСЭН ҮҮРГЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХГҮЙ БАЙГААГ
ХАРУУЛЖ БАЙНА.**

Агуулга

Тайланг бэлтгэсэн:

Говь-Алтай аймгийн Аудитын
газрын
I баг

Дарга, Тэргүүлэх аудитор
Х.Түвшинбаяр
Утас: 99489309

Аудитын менежер
Д.Эрдэнэчимэг
Утас: 99175677

Ахлах аудитор
Ж.Бүжинханд
Утас: 94008898

Шинжээч
Н.Монголжийбуу
Утас: 94008818

Шинжээч
Г.Энхдэлгэр
Утас: 99002291

2015 оны 10 дугаар сар

Аудитын тайлантай
холбоотой асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах зүйл
байвал 70483413, 70484030
дугаарын утас, 70483413
дугаарын факсаар харилцана
уу.

Хаяг:
Говь-Алтай аймаг
Есөнбулаг сум
Баянхайрхан баг

Товчилсон үгсийн жагсаалт.....
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....

Бүлэг нэг. Уул уурхайн нөхөн сэргээлтийн баталгаа хөрөнгийг хууль тогтоомжид заасны дагуу тооцож төвлөрүүлээгүй байна.

1.1 Нөхөн сэргээлтийн баталгааны мөнгөн хөрөнгийг бусад дансуудтай холилгүй, төрийн сангийн БХНС-ийн баталгаа хөрөнгийн дансанд төвлөрүүлэх шаардлагатай байна.

1.2 БОМТ батлуулсан ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид 92,137.5 мянган төгрөгийн, хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчид 32,694.1 мянган төгрөгийн баталгаа мөнгөн хөрөнгийг дутуу байршуулж, 2013-2015 онуудад хүчинтэй хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь 2007-2015 онуудад давхардсан тоогоор 763 БОМТ батлуулаагүй байна.

Бүлэг хоёр. БХНС-ийн тусгай дансанд төвлөрсөн баталгаа мөнгөн хөрөнгийг журамд заасны дагуу зарцуулаагүй байна.

2.1 Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчид байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу нөхөн сэргээлтийг бүрэн хийснийг нотлох баримт хангалтгүй байна.

2.2 Лиценз эзэмшигчдийн төвлөрүүлсэн байгаль хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгаа хөрөнгөнөөс 279,881.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулжээ.

Бүлэг гурав. Орон нутгийн захиргаа, мэргэжлийн болон тусгай зөвшөөрөл эзэмшигчид хуулиар хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Зөвлөмж:.....
Холбогдох байгууллагын санал.....
Хавсралт.....

Товчилсон үгийн жагсаалт

МУ	Монгол улс
УИХ	Улсын их хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ААГ	Аймгийн аудитын газар
ЗГ	Засгийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ХО	Хөрөнгө оруулалт
ААН	Аж ахуйн нэгж
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
НББ	Нягтлан бодох бүртгэл
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлэх сан
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
БХНС	Байгаль хамгаалах нөхөн сэргээлт
БОНХЯ	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн орон улсын стандарт
БОАЖГ	Байгаль орчин аялал, жуулчлалын газар
БОМТ	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
БОБЗХМ	Байгаль орчны бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, бэрхшээл

Аудит хийх үндэслэл үндэслэл, бүрэн эрх

Аудитыг УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2014 оны 20 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт УАГ-аас 2015 онд нийлүүлэх бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөө, Говь-Алтай аймгийн Аудитын газрын 2015 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон төрийн аудитын төрөлжсөн болон орон нутаг дахь салбар байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Уул уурхайн нөхөн сэргээлтийн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалт, үр дүн”-д гүйцэтгэлийн аудит хийлээ.

Аудитын зорилт, хамарсан хүрээ

Уул уурхайн нөхөн сэргээлтийн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалт, үр дүнд үнэлгээ, дүгнэлт өгч дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах үндсэн чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ.

Үүнд:

- ✓ Уул уурхайн нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг хууль тогтоомжид заасны дагуу тооцож төвлөрүүлсэн эсэх
- ✓ Төвлөрүүлсэн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу зарцуулсан эсэх
- ✓ Төв орон нутгийн захиргаа, мэргэжлийн болон тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хуулиар хүлээсэн үүрэг хэрэгжиж буй эсэх

Аудитын хамарсан хүрээ

Аудитад Говь-Алтай аймгийн хэмжээнд сумдын 2007-2015 онд Уул уурхайн нөхөн сэргээлтийн хөрөнгө төвлөрүүлэлт, зарцуулалт, үр дүнгийн биелэлтийг хариуцсан төрийн байгууллагуудын /УУЯ, БОНХАЖЯ, МХЕГ, аймаг, нийслэлийн ЗДТГ ба бусад/ тайлант жилүүдэд хэрэгжүүлсэн арга хэмжээ, хамтын ажиллагаа, шийдвэр гаргалт, тэдгээрийн үр нөлөө, хэрэгжилтийн талаарх тайлан, мэдээ, ажлын баримт материал, хөндлөнгийн хараат бус байгууллагын судалгаа, шинжилгээний үнэлгээ дүгнэлтийг хамруулан шалгав.

Үндсэн мэдээлэл:

Уул уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшигч ААН-ээс байгаль орчныг нөхөн сэргээх хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа нь Байгаль орчныг хамгаалах, Газрын хэвлийн тухай, Ашигт малтмалын тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиуд, байгаль орчны болон уул уурхайн асуудал эрхэлсэн яам, агентлагаас гаргасан дүрэм журмаар зохицуулагдаж байна.

Байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэхийн баталгаа болгон тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлынхаа 50-иас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг тус сум, дүүргийн Засаг даргын дэргэдэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлтийг жил бүр тайлагнадаг.

Бүх төрлийн ашигт малтмалын хайгуул, ашиглалт, баяжуулах, боловсруулах үйлдвэр, химийн үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэх аж ахуй нэгжүүд байгаль орчны асуудал

хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын нөхөн сэргээлтийн тусгай дансанд мөнгөн хөрөнгө төвлөрүүлдэг.

Энэхүү тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журмыг Байгаль орчин ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А/04 тушаалаар баталсан байна.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хүлээсэн үүргээ биелүүлсэн бүх төрлийн ашигт малтмалын ашиглалт, баяжуулах, боловсруулах үйлдвэр, химийн үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэх төсөл хэрэгжүүлэгчид тусгай дансанд байршуулсан мөнгөн хөрөнгийг тухайн жилийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын гүйцэтгэлийг харгалзан буцаан олгодог.

Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлээгүй буюу бүрэн хэрэгжүүлээгүй тохиолдолд Ашигт малтмалын тухай хуулийн 39.3 дахь заалтад үндэслэн байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага зохих шатны Засаг дарга, Байгаль орчны газартай хамтран нөхөн сэргээлтийн ажлыг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх бөгөөд нэмж шаардагдах хөрөнгийг төсөл хэрэгжүүлэгчээс үл маргах журмаар гаргуулахаар хуульд тусгагдсан.

Аудитын арга зүй

Аудитын явцад Төрийн хяналт шалгалтын стандартын хүрээнд гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан, аудитын хөтөлбөрийн дагуу холбогдох горимоор нотлох зүйл цуглуулж, мөрдөгдөж буй хууль, тогтоол, түүнийг дагалдан гаргасан эрх зүйн актуудын хүрээнд хэрэгжүүлэгч байгууллага, нэгжийн холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, санал асуулга, лавлагаа, тодруулга авах, сумдын байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн дансны хуулга, санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийн аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглууллаа. Үүнд:

- ✓ Баталгааны мөнгөн хөрөнгө байршуулсан дансны хуулгыг нэг бүрчлэн боловсруулж, төрийн санд нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн дансыг нээсэн эсэхийг судалж үзлээ.
- ✓ 2013-2015 оны хооронд хүчинтэй тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хайгуулын лиценз эзэмшигчийн хувьд 2007 оноос хойш, ашиглалтын лиценз эзэмшигчийн хувьд 2013 оноос хойших хугацааг хамруулан дараах судалгааг хийсэн. Үүнд:

а /Байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлуулсан эсэхийг

б /Баталгааны мөнгөн хөрөнгийг байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлаас хуульд заасан хувиар эрх бүхий байгууллагаас тогтоосон хугацаанд байршуулсан эсэх

в /Тусгай зөвшөөрөл эзэмшигч жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан гаргаж өгдөг эсэх

г/ Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу нөхөн сэргээлтийг бүрэн хийсэн эсэх

д/ Баталгааны мөнгөн хөрөнгийн буцаан олголтыг үндэслэлтэйгээр олгосон эсэхтэй танилцсан.

- ✓ Нөхөн сэргээлтийн баталгааны мөнгөн хөрөнгийг холбогдох хууль журмын дагуу зарцуулсан эсэхийг судалсан.
- ✓ БОНХЯ нь хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлж байгаа эсэхийг үзлээ.

- ✓ Тусгай дансны орлогын бүрдүүлэлт, зарцуулалтын тайланг ИТХ-аар хэлэлцүүлсэн эсэх, Орон нутгийн удирдлага, мэргэжлийн байгууллагууд хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байгаа эсэхийг үзсэн.
- ✓ Тусгай зөвшөөрөл эзэмшигчид нь хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байгаа эсэхийг судаллаа.
- ✓ Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг газар дээр нь шалгалаа.

Аудитын стандартын талаархи мэдэгдэл

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, гүйцэтгэлийн шалгалтын журам, гүйцэтгэлийн аудитын гарын авлагыг ашигласан болно.

Аудитад хамрагдсан хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дараах хууль, эрхийн акт, баримт бичгийг аудитын шалгуур болгон ашигласан. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Ашигт малтмалын тухай хууль
- Газрын хэвлийн тухай хууль
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
- Байгаль орчны сайдын 2007 оны 1 дүгээр сарын 09-ний өдрийн “Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам”, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 04 дүгээр тушаал
- Уул уурхайн нөхөн сэргээлттэй холбоотой стандартууд:
 - MNS5914:2008. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн нэр томъёо, тодорхойлолт
 - MNS5915:2008. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал
 - MNS5916:2008. Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрс хуулалт, хадгалалт.
 - MNS5917:2008. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн шаардлага.
- Гүйцэтгэлийн аудитын гарын авлага
- Дээрх хуулиудыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан Засгийн газрын тогтоол, холбогдох бусад хууль, эрхийн актууд

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн шалгалтын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэнд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитыг хийсэн багийн бүрэлдэхүүн

Тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр аудитыг удирдан зохион байгуулж, аудитын менежер Д.Эрдэнэчимэг явцын болон чанарын хяналт тавьж, I багийн ахлах аудитор Ж.Бүжинханд, шинжээч Н.Монголжийбуу, шинжээч Г.Энхдэлгэр нар 09 дүгээр сарын 07-ны өдрөөс 11 дүгээр сарын 01-ний хооронд хийж гүйцэтгэв.

Аудит хийхэд учирсан бэрхшээл

Аудитыг хийхдээ аймгийн бүх сумдыг хамруулсан бөгөөд, мэргэжлийн шинжээч авч ажиллуулаагүй, нөгөө талаас ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн менежментийн төлөвлөгөө, нөхөн сэргээлт хийсэн, хүлээж авсан анхан шатны баримтын

материал дутуу, нөхөн сэргээлтийн баталгаа хөрөнгийг төрийн сангийн тусгай дансанд байршуулаагүй, арилжааны банк, СХС, ОНХС, ОНХО-ын дансанд дамжуулан төвлөрүүлж зарцуулсан нь тооцоо судалгаа хийхэд хүндрэлтэй байлаа.

I Бүлэг. Уул уурхайн нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг хууль тогтоомжид заасны дагуу тооцож төвлөрүүлсэн байна уу?

Уул уурхайн нөхөн сэргээлтийн баталгаа хөрөнгийг хууль тогтоомжид заасны дагуу тооцож төвлөрүүлээгүй байна.

1.1 Нөхөн сэргээлтийн баталгааны мөнгөн хөрөнгийг бусад дансуудтай холилгүй, төрийн сангийн БХНС-ийн баталгаа хөрөнгийн дансанд төвлөрүүлэх шаардлагатай байна.

Говь-Алтай аймгийн хэмжээнд 2015 оны 09 сарын 11-ны байдлаар ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч 27, хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч 205 бүртгэгдсэн байна.

Байгаль орчны сайдын 2007 оны 1 дүгээр сарын 09-ний өдрийн “Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам”-ын 1.3¹, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 04 дүгээр тушаалын хавсралтын 1.1² -д заасны дагуу сумдын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн баталгааны тусгай данс нь сум, дүүргийн төрийн санд байршихаар заагджээ.

Сумдын байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн баталгааны мөнгөн хөрөнгө байршуулсан дансны хуулийг 2007 оноос 2015 оны 10 сар хүртэлх хугацаанд хамруулан нэг бүрчлэн боловсруулж, төрийн санд нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн данс нээсэн эсэхийг судалж үзлээ. Судалгааны нэгтгэлийг дараах хүснэгтээр харуулбал:

Нөхөн сэргээлтийн баталгаат мөнгөн хөрөнгийг байршуулсан дансны мэдээлэл

¹ 1.3-д /Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн баталгааны тусгай данс нь сум, дүүргийн төрийн санд байршина./

² 1.1-д /Энэхүү журмаар төсөл хэрэгжүүлэгчийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгааны мөнгөн хөрөнгийг байршуулах төрийн сангийн тусгай дансны /цаашид “тусгай данс” гэх/ орлого, зарлагын гүйлгээнд хяналт тавихтай холбогдсон бусад харилцааг зохицуулна./

Хүснэгт-1

/Төгрөг/

Дансны 2007-2015 оны 10 сар хүртэлх хугацааны мэдээлэл					
Банкны нэр	Дансны нэр	Эхний үлдэгдэл	Орлого	зарлага	Эцсийн үлдэгдэл
Төрийн сан	БХНСэргээлт барьцаа	0	304356797.8	149300190	155056607.8
Арилжааны банк	Байгаль хамгаалах сан	1624912	485124620.8	486749532.8	0
Төрийн сан	Орон нутгийн ерөнхий орлогын данс	0	49072675	47487058	1585617
Төрийн сан	ОНХСан	0	15000000	7000000	8000000
Төрийн сан	ЗДТГ	0	14637058	14637058	0
Арилжааны банк	Сум хөгжүүлэх сан	0	38974832.05	38638082.05	336750
Төрийн сан	Сум хөгжүүлэх сан	0	290179797	274907797	15272000
Нийт дүн		1624912	1197345781	1018719718	180250974.8

Дээрх судалгаанаас үзэхэд аймгийн хэмжээнд 2014 онд нэгдсэн журмаар “Байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн баталгаа хөрөнгийн дансыг төрийн сангийн тусгай дансанд шинээр байршуулсан ба үүнээс өмнөх онуудад нөхөн сэргээлтийн баталгаа хөрөнгийг Байгаль хамгаалах сан, ОНХС, СХС, ОНХО-ын дансаар дамжуулан төвлөрүүлж зарцуулсан байгаа нь БОНХЯ-ны сайдын баталсан “Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.1 дэх заалтыг зөрчсөн үйл ажиллагаа болсон байна. Хавсралт-1

Одоогийн байдлаар Байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн баталгаа хөрөнгийн дансны үлдэгдэл 180,250.9 мянган төгрөг байгаа бөгөөд үүний 155,056.6 мянган төгрөг нь төрийн сан дахь БХНС-ийн барьцаа хөрөнгийн дансны үлдэгдэл, 1,585.6 мянган төгрөг нь ОНХО-д, 8,000.0 мянган төгрөг нь ОНХС-д, 15,608.7 мянган төгрөг нь Сум хөгжүүлэх сангийн дансанд төвлөрсөн байна.

БХНС-ийн баталгаа хөрөнгийн 155,056.6 мянган төгрөгийн үлдэгдлээс 75,003.2 мянган төгрөг нь Аймгийн ИТХ-ын 2015 оны 48, 69, 76 дугаар тогтоолоор баталсан эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийх ААНБ, хоршоодын түр байршуулсан барьцаа төлбөр бөгөөд үлдсэн 80,053.4 мянган төгрөг нь хайгуулын тусгай зөвшөөрөлтэй ААНБ-ын байршуулсан баталгаа хөрөнгийн үлдэгдэл юм.

ОНХО-ын дансанд байршуулсан 1,585.6 мянган төгрөгийг сумдаар харуулбал Жаргалан сум 400.0 мянган төгрөг, Халиун сум 585.6 мянган төгрөг, Хөхморьт сум 600.0 мянган төгрөгийн байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн баталгаа хөрөнгийг ОНХО-д төвлөрүүлсэн байна.

Мөн Алтай сум нь Байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн баталгаа хөрөнгийн дансны үлдэгдлээс 2015 онд үндэслэлгүйгээр 10,000.0 мянган төгрөгийг ОНХС-д шилжүүлж 2,000.0 мянган төгрөгийг лиценз эзэмшигч компанийн үйл ажиллагаандаа зарцуулах зөвшөөрлийн хүрээнд хийсэн гэрээний дагуу зарцуулж, 8,000.0 мянган төгрөгийг үлдээсэн байна.

Харин СХС-гийн дансанд төвлөрсөн 15,608.8 мянган төгрөгийг сумдаар харуулбал Алтай сум 2,710.5 мянган төгрөгийг, Эрдэнэ сум 11,515.1 мянган төгрөгийг, Тонхил сум 1,046.4 мянган төгрөгийг, Төгрөг сум Байгаль хамгаалах сангийн хөрөнгөнөөс өвс тэжээл бэлтгэн, өвсний үнэ болох 336.8 мянган төгрөгийг СХС-гийн дансанд төвлөрүүлжээ. Алтай сумын 2,710.5 мянган төгрөгийг 2015 оны санхүүгийн тайлангийн баталгаажуулах аудитаар төлүүлэх төлбөрийн акт тогтоосон байна.

Дээрх сумдын ОНХС-д шилжүүлсэн 8,000.0 мянган төгрөг, СХС-д байршуулсан 12,898.3 мянган төгрөг, ОНХО-д байршуулсан 1,585.6 мянган төгрөг нийт 22,483.9 мянган төгрөгийн байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн баталгаа хөрөнгийг сумдын төрийн сан дахь БХНС-ийн баталгаа хөрөнгийн тусгай дансанд байршуулах шаардлагатай байна.

1.2 БОМТ батлуулсан ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид 92,137.5 мянган төгрөгийн, хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчид 32,694.1 мянган төгрөгийн баталгаа мөнгөн хөрөнгийг дутуу байршуулж, 2013-2015 онуудад хүчинтэй хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь 2007-2015 онуудад давхардсан тоогоор 763 БОМТ батлуулаагүй байна

Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тухайд

Аймгийн хэмжээнд өнөөдрийн байдлаар 15 аж ахуй нэгжид ашиглалтын тусгай зөвшөөрөл олгогдсон 27 талбай байна. Үүнээс 5 аж ахуй нэгж 9 талбай дээр уурхайн олборлолт явуулснаас одоогоор 3 аж ахуй нэгж 6 талбайд олборлолт явуулж байна. Олборлолт явуулж байгаа компаниудаас “Мандал-Алтай” группын “Хөв булгийн уурхай”-г эс тооцвол 2013-2015 онуудын жил бүрийн БОМТ, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт нөхөн сэргээлт хийхээр тусгаагдаагүй боловч бусад тусгаагдсан ажлуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.10³-т заасны дагуу тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлэх ёстой.

Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулж, баталгааны мөнгөн хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу байршуулсан байдлын судалгааг аймгийн хэмжээнд олборлолт явуулж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн 2013-2015 оны үйл ажиллагааг хамруулан тооцоолол хийлээ. /Хавсралт №2а/

Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулж, баталгааны мөнгөн хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу байршуулсан байдлын судалгаа

³ 9.10-т /Ашигт малтмалын ашиглалт, баяжуулах, боловсруулах үйлдвэр, химийн үйлдвэрийн үйл ажиллагааны төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нөхөн сэргээлтийн тусгай дансанд ашиглалтын үйл ажиллагаа дуусах хүртэл жил бүр тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг төвлөрүүлнэ./

Хүснэгт-2

/Төгрөг/

ДД	Сумын нэр	Лиценз эзэмшигч йн тоо	Олборлолт		Ашиглалтын лицензийн хувьд 2013-2015 оны 10 сар хүртэлх хугацаанд жил бүрийн давхардсан тоогоор			Нөхөн сэргээлтийн баталгаа хөрөнгө байршуулсан		Дутуу төвлөрүүлсэн	
					Байгаль орчны менежмент ийн	БОНХС-ийн төлөвлөгөө батлуулсан лиценз эзэмшигчийн					
			Ү/а явуулсан	Ү/а огт эхлээгүй байгаа	Батлуулсан лиценз эзэмшигч	нөхөн сэргээлтэнд шаардлагат ай мөнгөн хөрөнгө	Байршуулах ёстой мөнгөн хөрөнгө	Лиценз эзэмшигч йн тоо	Баталгаат мөнгөн хөрөнгө	Лиценз эзэмшигч йн тоо	Баталгаат мөнгөн хөрөнгө
1	Алтай сум	1	-	1	-	-	-	-	-	-	-
2	Бигэр сум	2	2	-	6	390,275,000	195,137,500	6	85,274,500	-	725,500
3	Бугат сум	1	-	1	-	-	-	-	-	-	-
4	Дэлгэр сум	1	1	-	-	-	-	-	-	-	-
5	Тайшир сум	3	-	3	-	-	-	-	-	-	-
6	Тонхил сум	1	-	1	-	-	-	-	-	-	-
7	Төгрөг сум	7	1	6	-	-	-	-	-	-	-
8	Цээл сум	4	2	2	7	186,330,000	93,165,000	1	31,080,000	-	62,085,000
9	Чандмань сум	4	3	1	9	17,264,000	8,632,000	9	5,305,000	-	3,327,000
10	Шарга сум	1	-	1	-	-	-	-	-	-	-
11	Эрдэнэ сум	1	-	1	-	-	-	-	-	-	-
12	Есөнбулаг сум	1	-	1	-	-	-	-	-	-	-
НИЙТ		27	9	18	22	593,869,000	296,934,500	16	121,659,500	-	66,137,500

Дээрх судалгаанаас үзэхэд БОНХЯ-д 296,934.5 мянган төгрөгийн БХНС-ийн баталгаа хөрөнгийг төвлөрүүлэх ёстой байтал 121,659.5 мянган төгрөгийг байршуулж, 66,137.5 мянган төгрөгийг дутуу байршуулжээ.

Баталгааны мөнгөн хөрөнгийг дутуу байршуулсан зөрчлийг сумдаар болон зөвшөөрөл эзэмшигч ААНБ-аар онцолж үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

- ❖ Бигэр сумын Булаг нэртэй газар олборлолт явуулж байсан ашиглалтын MV-017117, MV-015636 дугаарын лицензтэй “Марко Поло” ХХК-ийн тухайд жил бүр техникийн нөхөн сэргээлтийг бүрэн хийн, БОАЖГ-ын даргаар ахлуулсан комисст хүлээлгэн өгсөн байна. БОНХЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газарт 2011-2014 онуудад 85,274.5 мянган төгрөгийг байршуулсан ба жил бүр техникийн нөхөн сэргээлтийг хийж, дүгнүүлээд байхад БОНХЯ нь төвлөрүүлсэн баталгаа хөрөнгийг буцаан олгоогүй байна.

“Марко Поло” ХХК нь 2015 онд төвлөрүүлэх ёстой 86,000.0 мянган төгрөгөнд өмнөх онуудад байршуулсан баталгаа хөрөнгийг шилжүүлж тооцуулах хүсэлт гаргасан ба үүнийг харгалзан үзвэл 725.5 мянган төгрөг дутуу байршуулжээ.

- ❖ Цээл сумын Таян нуур нэртэй газар олборлолт явуулж байгаа ашиглалтын MV-013527, MV-015377 дугаарын лицензтэй “Алтайн хүдэр” ХХК нь 2013, 2014 онуудад баталгаа хөрөнгө огт байршуулаагүйгээс 2013-2015 онуудад 62,085.0 мянган төгрөг дутуу байршуулжээ.
- ❖ Чандмань сумын Зээгт, Шар хоолой, Асгат нэртэй уурхайд олборлолт явуулж байгаа ашиглалтын MV-000905, MV-011965, MV-014217 дугаарын лицензтэй “Гобикоул энд энерги” ХХК нь 2013-2015 онуудад нийт 3,327.0 мянган төгрөг дутуу байршуулжээ.

Дээрх зөрчил нь БОНХЯ-аас тавьж байгаа хяналт сул байгааг харуулж байгаа ба цаашид тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн байршуулах ёстой мөнгөн хөрөнгийг бүрэн

байршуулсан эсэхэд хяналт тавьж, нөхөн сэргээлт хийснийг аймгийн Засаг даргын томилсон комисс дүгнээд хүргүүлсэн тохиолдолд баталгаа хөрөнгийг буцаан олгож байх шаардлагатай байна.

Аймгийн БОАЖГ-аас ирүүлсэн судалгаагаар Дэлгэр сумын нутагт байрлах ашиглалтын MV-017121 дугаарын лицензтэй Хөв булгийн уурхайг эзэмшигч “Мандал Алтай” групп нь 2013-2015 онуудад нүүрс тасралтгүй олборлосон боловч БОНХЯ-аар байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг батлуулаагүй, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нөхөн сэргээлтийн тусгай дансанд баталгааны мөнгөн хөрөнгийг огт байршуулаагүйгээр үйл ажиллагаа явуулж байгаа нь Ашигт малтмалын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 35 дугаар зүйлийн 35.1⁴, 37 дугаар зүйлийн 37.1⁵-ыг зөрчсөн үйл ажиллагаа болсон байна.

Иймээс БОНХЯ, аймгийн БОАЖГ, МХГ, Орон нутгийн удирдлага хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй бөгөөд уурхайн үйл ажиллагааг зогсоох, эсвэл Байгаль орчны нарийвчилсан үнэлгээг хийлгэхийг шаардаж, байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг батлуулан баталгаа мөнгөн хөрөнгийг тусгай дансанд байршуулсан тохиолдолд олборлолтын үйл ажиллагааг явуулах эрхийг өгөх шаардлагатай байна.

Нийт ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын тухайд баталгаа мөнгөн хөрөнгийг илүү төвлөрүүлээгүй байна.

Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тухайд

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.9⁶, Ашигт малтмалын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.8⁷-т заасны дагуу 2013 он, 2014 он, 2015 оны 9 дүгээр сарын 11-ний өдрөөр хүчинтэй байгаа хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хайгуулын талбай байрших сумын Засаг даргаар батлуулсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөг үзэн, байгаль орчин нөхөн сэргээхэд шаардлагатай мөнгөн хөрөнгийн 50-иас доошгүй хувийг баталгаа хөрөнгө болгон сумын Засаг даргын дэргэдэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлсэн байдалд тооцоолол хийлээ.

⁴ 35.1-д /Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашигт малтмал эрэх, хайх, ашиглахдаа энэ зүйлд заасан нийтлэг үүргийг биелүүлж ажиллах бөгөөд зөрчвөл энэ хуулийн 66.1.4-т заасан хариуцлага хүлээнэ./

⁵ 37.1-д /Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж болон энэ хуулийн 38, 39 дүгээр зүйлд заасан үүргийг биелүүлнэ./

⁶ 9.9-т /Энэ хуулийн 9.10-т зааснаас бусад төрлийн төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэхийн баталгаа болгон тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлынхаа 50-иас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг тус сум, дүүргийн Засаг даргын дэргэдэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлтийг жил бүр тайлагнана/

⁷ 38.1.8-д /байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгон холбогдох сум, дүүргийн Засаг даргын нээсэн тусгай дансанд байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд шаардагдах тухайн жилийн зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг шилжүүлэх/

Байгаль орчны сайдын “Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам” нь 2007 онд батлагдсан учраас мөнгөн хөрөнгө төвлөрүүлэлтийг 2007 оноос 2015 оны хүртэлх хугацааны дансны хуулга боловсруулсан. Үүнтэй холбоотойгоор тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг 2007-2015 оныг хамруулан үзлээ. /Хавсралт №26/

Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн баталгааны мөнгөн хөрөнгө байршуулсан байдал

Хүснэгт-3

/Төгрөг/

Хайгуулын лицензийн хувьд 2007-2015 оны 10 сар хүртэлх хугацаанд жил бүрийн давхардсан тоогоор

Нөхөн сэргээлтийн баталгаа хөрөнгө байршуулсан

Дутуу төвлөрүүлсэн

Илүү төвлөрүүлсэн

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө		БОНХС-ийн төлөвлөгөө батлуулсан лиценз эзэмшигчийн		Нөхөн сэргээлтийн баталгаа хөрөнгө		Дутуу төвлөрүүлсэн		Илүү төвлөрүүлсэн	
Батлуулах боломжтой лиценз эзэмшигч	Батлуу лсан лиценз эзэмши гч	нөхөн сэргээлтэнд шаардлагаат ай мөнгөн хөрөнгө	Байршуулах ёстой мөнгөн хөрөнгө /төгрөг/	Лиценз эзэмши гчийн тоо	Баталгаат мөнгөн хөрөнгө /төгрөг/	Лиценз эзэмши гчийн тоо	Баталгаа т мөнгөн хөрөнгө /төгрөг/	Лице нз эзэм шигч ийн тоо	Баталгаат мөнгөн хөрөнгө /төгрөг/
1,217	454	330,935,270	165,467,635	292	183,927,000	162	32,694,035	87	51,153,400

Аймгийн хэмжээнд Баян-Уул сумыг эс тооцвол 17 сумын нийт тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хувьд 2007-2015 онуудад давхардсан тоогоор 1217 байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлуулах боломжтой байсан ба байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд байгаль хамгаалахад шаардагдах мөнгөн дүнг 330,935.3 мянган төгрөгөөр тусгаж 165,467.6 мянган төгрөгийг сумын Засаг даргын дэргэдэх байгаль хамгаалах, нөхөн сэргээлтийн дансанд байршуулахаар 454 байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулжээ.

Төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгө, илүү, дутуу байршуулсан байдлыг дээрх хүснэгтээс харахад нийт байршуулах ёстой мөнгөн хөрөнгөнөөс 157 компани 32,694.0 мянган төгрөгийг дутуу, 87 компани 51,153.4 мянган төгрөгийг илүү байршуулжээ.

Байгаль орчин ногоон хөгжлийн яамны сайдын 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 04 тоот тушаалаар батлагдсан “Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам”-ын 2.3.5⁸ -д заасны дагуу хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тухайд баталгаа хөрөнгийг байршуулах хугацааг тогтоож, тогтоосон хугацаанд тусгай дансанд байршуулаагүй тохиолдолд хоног тутамд алданги тооцсон эсэхийг 2014-2015 онуудад судалж үзэхэд бүх сумын тухайд баталгаа хөрөнгийг байршуулах хугацааг эрх бүхий байгууллагаас тогтоож өгдөггүй бөгөөд хугацааг тогтоож өгдөггүйн улмаас алданги огт тооцоогүй байна.

⁸ 2.3.5-д /Баталгааны мөнгөн хөрөнгийг эрх бүхий байгууллагаас тогтоосон хугацаанд тусгай дансанд байршуулаагүй бол хоног тутамд 0.01 хувийн алданги тооцно/

Иймд Засаг дарга БОМТ-г батлахдаа мөнгөн хөрөнгө байршуулах хугацааг тогтоож, хугацаандаа байршуулаагүй тохиолдолд журамд заасны дагуу алдангийг тооцож төвлөрүүлж байх, сумын Байгаль орчны бодлого зохицуулалтын мэргэжилтэн, улсын байцаагчийн ажил үүргээ гүйцэтгэхдээ хариуцлагатай хандаж, тусгай зөвшөөрөл эзэмшигч компанитай нягт уялдаа холбоотой ажиллан, нэгэнт БОМТ батлуулсан бол байршуулах мөнгөн хөрөнгийг шаардаж, дутуу байршуулж байгаад хяналтаа байнга тавих шаардлагатай байна.

Мөн БОМТ огт батлуулаагүйгээр тусгай дансанд 2007-2015 оны хооронд 148 тусгай зөвшөөрөл эзэмшигчээс 42,970.0 мянган төгрөгийг байршуулсан нь Ашигт малтмалын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.3⁹, 48 дугаар зүйлийн 48.1.1¹⁰ дэх заалтыг тус тус зөрчсөн байна. Үүнийг ихэнх сумын БОБЗХ мэргэжилтэн, улсын байцаагч нар “БОМТ-г архивын нэгж болгож архивт хадгалдаагүй, олон жилийн өмнөх төлөвлөгөө алга болсон, байцаагч солигдсон тохиолдолд өмнөх байцаагчийн материал хүлээлгэж өгөөгүй” гэж тайлбарлаж байгаа нь ажлын хариуцлага сул байгааг мөн илэрхийлж байна.

II Бүлэг. Төвлөрүүлсэн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу зарцуулсан байна уу ?

БХНС-ийн тусгай дансанд төвлөрсөн баталгаа мөнгөн хөрөнгийг журамд заасны дагуу зарцуулаагүй байна.

2.1 Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчид байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу нөхөн сэргээлтийг бүрэн хийснийг нотлох баримт хангалтгүй байна.

Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хувьд одоогоор үйл ажиллагаа зогсоосон байгаа 2 аж ахуй нэгжийн тухайд дараах байдалтай байна. Үүнд:

- ❖ Бигэр сумын нутагт 2 талбайтай “Марко Поло” ХХК нь 2014 онд олборлолтоо зогсоож, 2011-2015 онуудад жил бүр нөхөн сэргээлтийг хийн аймгийн БОАЖГ-ын даргаар ахлуулсан комисст хүлээлгэн өгч ажиллажээ. “Марко Поло” ХХК нь 2013 онд 4.3 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийсэн боловч шаардлага хангаагүй байсны улмаас комисс хүлээж аваагүй бөгөөд 2015 онд Аймгийн МХГ-аас биологийн нөхөн сэргээлтийг хийх шаардлага өгсөн байна.
- ❖ Төгрөг сумын нутагт орших “Мааньтын уурхай” -д “Мандал-Алтай” групп нь 2010 он хүртэл 26.66 га талбайд нүүрсний олборлолт хийсэн бөгөөд тус онд үйл ажиллагаагаа зогсоосон боловч одоог хүртэл огт нөхөн сэргээлт хийгдээгүй

⁹ 8.1.3-д /энэ хуулийн 38.1.1-д заасан төлөвлөгөөг тухайн хайгуулын талбай байрших сум, дүүргийн Засаг даргад хүргүүлж батлуулах/

¹⁰ 48.1.1-д /хайгуулын ажлын төлөвлөгөөг хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдсон өдрөөс хойш 30 хоногийн, дараагийн жилүүдэд тухайн оны төлөвлөгөөг 04 дүгээр сарын 15-ны дотор батлуулна/

байгааг цаашид анхааралдаа авч нөхөн сэргээлтийг хийлгүүлэх шаардлагатай байна. Хавсралт-3а, 3б

Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хувьд:

Ашигт малтмалын тухай хуулийн 37-р зүйлийн 37.1¹¹ -д заасны дагуу байгаль хамгаалах талаар БОМТ батлуулсан, төлөвлөгөөний дагуу нөхөн сэргээлтийг бүрэн хийсэн эсэхэд нийт 250 хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн 2007-2015 оны нөхөн сэргээлттэй холбоотой материалыг хамруулан судалгаа хийлээ. /Хайгуулын талбай нь сум дамнасан тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тухайд тухайн сум бүр дээр нэмэгдсэн байгаа учраас тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр давхардан орсон/. /Хавсралт 4а/

Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчид 2007-2015 онуудад давхардсан тоогоор нийт 1217 байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлуулан хайгуул хийх боломжтой байснаас 454 төлөвлөгөө батлуулж, 462 хайгуул хийсэн байна. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн жил жилийн хайгуул хийснийг нотлох баримт байгаагүй бөгөөд БОБЗХ мэргэжилтэн, улсын байцаагч нараас тодруулсны үндсэн дээр нийт хайгуулын ажлын тоог гаргасан болно

Бид аудитын хамрах хугацаанд хайгуулын ажлын төлөвлөгөө, тайлан, БОМТ, төлөвлөгөөний биелэлтийг ирүүлдэг эсэхийг судалж үзэхэд “Хайгуулын ажил дууссан үед БОБЗХ мэргэжилтэн, улсын байцаагч, байгаль хамгаалагч нар хайгуулын талбайг очиж үздэг” гэж БОБЗХ мэргэжилтэн тайлбарласан боловч албан ёсоор хүлээн авч баримтжуулсан ажил огт хийгдээгүй, шууд дүгнэлт гарган, дүгнэлтэндээ нөхөн сэргээлтийг бүрэн хийсэн гэсэн утгыг оруулдаг байна. Энэ нь хайгуулын талбайд хийсэн нөхөн сэргээлтийг хүлээн авсан гэж үзэх боломжгүй байдалд хүргэж байна.

Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн 2013, 2014 оны судалгаа
Хүснэгт-4

Он	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тоо /давхардсан тоогоор/	Хайгуулын		Байгаль хамгаалах		Нөхөн сэргээлт хийгдээгүй шалтгаан, тайлбар
		төлөвлөгөө хянуулсан эсэх	тайлан ирүүлсэн эсэх	төлөвлөгөө өг баталгаажуулж ирүүлсэн эсэх	төлөвлөгөөний биелэлтийг баталгаажуулж ирүүлсэн эсэх	
2013	144	19	47	74	2	Нөхөн сэргээлтийг бүрэн хийсэн
2014	141	22	65	64	2	Нөхөн сэргээлтийг бүрэн хийсэн
Нийт	285	41	112	138	4	

¹¹ 37.1-д /Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж болон энэ хуулийн 38, 39 дүгээр зүйлд заасан үүргийг биелүүлнэ./

Сумын БОБЗХ мэргэжилтэн, улсын байцаагчид нийт тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тухайд хайгуулын ажлын хувьд төлөвлөгөөг 14.4 хувь, тайланг 39.3 хувь ирүүлсэн байна. Харин БОМТ-ний биелэлтийг баталгаажуулж ирүүлсэн 4 төлөвлөгөөний биелэлтийг эс тооцвол БОМТ-ний биелэлтийг сумд огт ирүүлдэггүй байгаа нь БОБЗХ мэргэжилтэн, улсын байцаагчийн ажлын хариуцлагагүй байдал харагдаж байна. Хавсралт-4б

Үүнтэй холбоотойгоор аудитын явцад дараах зөрчил илэрсэн./Давхардсан тоогоор/ Үүнд:

- ✓ Байгаль орчны 454 менежментийн төлөвлөгөөг батлуулсан боловч 90 хайгуулын ажил огт хийгээгүй байна.
- ✓ Нийт 462 хайгуул хийснээс байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулалгүйгээр 104 хайгуулын ажлыг хийлгэсэн.
- ✓ Хайгуулын ажил дууссан тохиолдолд Байгаль орчны улсын байцаагч нөхөн сэргээлт хийсэн тухай 201 дүгнэлт гаргасан боловч энэ нь нөхөн сэргээлтийг бүрэн хийснийг /эсвэл газар эвдрээгүй гэдгийг/ нотлохгүй байгаа бөгөөд 261 хайгуулын талбайг албан ёсоор хүлээж авсан акт үйлдээгүй байна.
- ✓ БОБЗХ мэргэжилтэн нь “Хайгуулын ажлын улмаас эвдрээд эзэнгүй орхисон газар байхгүй, нөхөн сэргээлтийг бүрэн хийсэн” гэж тайлбарыг өгч байгаа боловч 250 /давхардсан тоогоор/ тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд буцаан олгох ёстой баталгаа мөнгөн хөрөнгө болох 222,622.0 мянган төгрөгийг буцаан олгоогүй байна.

Мөн 2013-2015 онуудад тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан, хугацааг сунгуулаагүй, талбайг буцаан өгсөн нийт 46 хайгуулын талбай байна. Эдгээрийг нөхөн сэргээлтээ бүрэн хийсэн эсэхэд судалгаа хийхэд “бүх компаниуд нөхөн сэргээлтийг бүрэн хийсэн” гэж БОБЗХ мэргэжилтэн, улсын байцаагч тайлбарыг өгсөн байна. /Хавсралт 5/

2.2 Лиценз эзэмшигчдийн төвлөрүүлсэн байгаль хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгаа хөрөнгөнөөс 279,881.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулжээ.

Байгаль орчны сайдын 2007 оны 1 дүгээр сарын 09-ний өдрийн “Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам”-ын 5.1¹², Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 04 дүгээр тушаалын хавсралтын 5.5¹³-д заасны дагуу сумдын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байршуулсан нөхөн сэргээлтийн баталгаа хөрөнгийг энэхүү журамд зааснаас бусад зориулалтаар ашиглах, зарцуулахыг хориглосон байна.

¹² 5.1-д /Тусгай дансны орлогын энэ журамд зааснаас өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно./

¹³ 5.5-д /Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож, тусгай дансанд байршуулсан мөнгөн хөрөнгийг энэхүү журамд зааснаас бусад зориулалтаар ашиглах, зарцуулахыг хориглоно./

Уг журамд “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хүлээсэн үүргээ биелүүлсэн бүх төрлийн ашигт малтмалын ашиглалт, баяжуулах, боловсруулах үйлдвэр, химийн үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэх төсөл хэрэгжүүлэгчид тусгай дансанд байршсан мөнгөн хөрөнгийг тухайн жилийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын гүйцэтгэлийг харгалзан буцаан олгох бол бусад төрлийн төсөл хэрэгжүүлэгчид тусгай дансанд байршуулсан хөрөнгийг тухайн жилийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын гүйцэтгэлийг харгалзан буцаан олгоно” гэж заажээ.

Мөн ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшсэн ААНБ нь байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн баталгаа хөрөнгийг БОНХЯ-ны тусгай дансанд төвлөрүүлж, харин хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын үйл ажиллагаа явуулж буй сумын БХНС-ийн тусгай дансанд байршуулах ёстой. Иймээс аудитаар ашигт малтмалын хайгуулын зөвшөөрөлтэй ААНБ-уудын сумдад төвлөрүүлсэн нөхөн сэргээлтийн баталгаа хөрөнгийн хувьд нарийвчлан судалгаа хийлээ.

БХНС-ийн баталгаа хөрөнгийн дансны орлого, зарлагын нэгтгэлийг дараах хүснэгтээр харуулья. Үүнд:

Байгаль орчныг нөхөн сэргээлтийн баталгаа хөрөнгөтэй холбоотой дансдын орлого зарлагын нэгтгэл /2007-2015 он/

Хүснэгт-5

/Төгрөг/

ДД	Сумын нэр	Нийт орлого	Бусад хүлээн зөвшөөрөгдөж болохуйц зардал				Дансны үлдэгдэл		Зориулалт бусаар зарцуулсан
			Буцаан олгосон	Орлого зарлагын хоорондын гүйлгээ	Хандивыг зарцуулсан	Лиценз эзэмшигчдийн зөвшөөрлөөр зарцуулсан	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	
1	Нөхөн сэргээлтийн баталгаа хөрөнгийн төвлөрсөн мөнгө	329246578	14550000			6400000			
2	Сумын ИТХ-ын шийдвэрээр нөхөн сэргээлт хийсэн	10000000	10000000						
3	Аймгийн ИТХ-ын шийдвэрээр ААНБ нөхөн сэргээлт хийхээр төвлөрсөн мөнгө	177003200	102000000						
4	Данснаас данс хоорондын гүйлгээ	177197110		177197110			1624912	180250975	279881055
5	ХААН банк онлайнд орсноор шинэ данс нээж үлдэгдэл суулгасан	20070209							
6	Дансаар дамжуулж, орлого оруулаад гаргасан гүйлгээ	315940231		315940231					
7	Хандив	108698082			99205772				
8	Банкны хүү	1804719		1332550					
9	Ангийн орлого	13000000		12213000					
10	Бусад орлого	44385652							
НИЙТ		1197345781	126550000	506682891	99205772	6400000	1624912	180250975	279881055

Дээрх нэгтгэлд дүгнэлт хийж үзвэл нөхөн сэргээлтийн баталгаа хөрөнгийн төвлөрсөн дүнгээс хайгуулын тусгай зөвшөөрөлтэй ААНБ-д буцаан олгосон болон лиценз эзэмшигчийн зөвшөөрлөөр зарцуулсныг хасаж үзэхэд одооны байдлаар 308,296.5 мянган төгрөгийн нөхөн сэргээлтийн баталгаа хөрөнгө дансанд байх ёстой байна.

Мөн аймгийн ИТХ-ын 2015 оны 48, 69, 76¹⁴ дугаар тогтоолоор шалгарсан ААНБ-уудаас байршуулсан барьцаа төлбөрийн үлдэгдэл 75,003.2 мянган төгрөг, ААНБ болон хайгуулын тусгай зөвшөөрөлтэй ААНБ-с өгсөн хандивын зарцуулаагүй үлдэгдэл 9,492.3 мянган төгрөг, ангийн орлогоос зарцуулаагүй 787.0 мянган төгрөг, арилжааны банкны дансанд мөнгө байршуулсны төлөө олгогдсон хүүгийн орлогоос банкны шимтгэлийг хасаж үзэхэд 472.2 мянган төгрөгийн, бусад орлого 44,385.6 мянган төгрөг болон дансны эхний үлдэгдэл /эхний үлдэгдэл болон ХААН банк онлайн сүлжээнд нэвтэрснээр үлдэгдлийг шинэ дансанд суулгасан/ 21,695.1 мянган төгрөгийн нийт 460,131.9 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байх ёстой байтал 2015 оны 10 сарын 15-ны байдлаар 180,250.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь 279,881.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсныг илэрхийлж байна.Хавсралт-6

БХНС-ийн баталгаа хөрөнгийн орлогын судалгааг сум бүрээр гаргасан бөгөөд Хавсралт-7-д дэлгэрэнгүйгээр харууллаа.

Зориулалт бусаар зарцуулсан 279,881.0 мянган төгрөгийг нохой, оготно утгахад, зөвшөөрөлгүйгээр алт олборлогчдыг хөөх үйл ажиллагаанд, булгийн эх хаших, худгийн засвар, үерийн далан хийх, Багийн төв барихад, халуун усны засварт, ахмадын өргөө, хурлын өрөөг тохижуулахад, сумын гэрэлтүүлэг, ширээ сандал авах, замын хашлага, гудамжны хайс хийхэд, мод, суулгац, зүлэгний үр, өвс тэжээл авахад, цэцэрлэгчийн цалин хөлс, бусад ажлын хөлсөнд, байгаль орчны байцаагчийн хувцас, техник хэрэгсэл авахад, хог цэвэрлэх, ачиж буулгах зардалд зарцуулсан бол бүр хэтрээд хүлээн авалт, гадаад, дотоод аялалын зардалд, сургалтын төлбөр төлөхөд, овоо тахилга, судар бичгийн үнэ, нутгийн зөвлөлийн уулзалт, сумын ойн үйл ажиллагаанд, тэтгэмж, тусламж, шагналд зарцуулсан байгаа нь Байгаль орчны сайдын 2007 оны 1 дүгээр сарын 09-ний өдрийн “Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам”-ын 5.1¹⁵, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 04 дүгээр тушаалын хавсралтын 5.5¹⁶-д заасныг зөрчсөн үйл ажиллагаа болжээ.Хавсралт-8

Гэвч энэ нь нэг талаас БХНС-ийн хөрөнгийн дансанд баталгаа болгон байршуулсан хөрөнгийг буцаан авах хүсэлтээ хайгуулын лиценз эзэмшигч ААНБ нь огт гаргадаггүй, нөгөө талаас төвлөрүүлсэн хөрөнгийг зарцуулах эрхийг нотлох баримтгүйгээр амаар тохиролцдогоос, мөн мөнгөн хөрөнгийг захиран зарцуулж байгаа эрх мэдэл бүхий албан тушаалтан нь “Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам”-ыг мэддэггүйтэй холбоотой дээрх зөрчил гарсан байна.

Байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн байршуулсан барьцаа хөрөнгийг аудитаар 2007 оноос хойш хамруулан үзсэн ба хүчинтэй, болон хүчингүй болсон лиценз эзэмшигчийн

¹⁴ Аймгийн ИТХ-ын 2015 оны 48, 69, 76 дугаар тогтоол “Аймгийн зарим газар нутагт нөхөн сэргээлт хийлгэх тухай”

¹⁵ 5.1-д /Тусгай дансны орлогын энэ журамд зааснаас өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно./

¹⁶ 5.5-д /Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож, тусгай дансанд байршуулсан мөнгөн хөрөнгийг энэхүү журамд зааснаас бусад зориулалтаар ашиглах, зарцуулахыг хориглоно/

хувьд байршуулсан БХНС-ийн баталгаа хөрөнгийн үлдэгдлийн судалгааг хийлээ. Үүнийг дараах хүснэгтээр харуулбал:

Байгаль орчныг нөхөн сэргээлтийн баталгаа хөрөнгийн үлдэгдэл

Хүснэгт-6

/төгрөг/

Нөхөн сэргээлтийн баталгаа хөрөнгийн 2007-2015 оны 10 сар хүртэлх хугацааны					
Төвлөрсөн мөнгө	Буцаан олгосон	Лиценз эзэмшигчдийн зөвшөөрлөөр зарцуулсан	Буцаан олговол зохих хөрөнгө	Үүнээс:	
				2015 онд хүчинтэй байгаа лиценз эзэмшигчийн төлбөр	2015 оноос өмнө хүчингүй болсон лиценз эзэмшигчийн төлбөр
329246578	14550000	6400000	308296578	159118000	149178578

Дээрх судалгаанаас үзэхэд хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч ААНБ-уудад буцаан олговол зохих баталгаа хөрөнгийн дүн 308,296.5 мянган төгрөг байгаа бөгөөд нийт 2015 оноос өмнө хүчингүй болсон лиценз эзэмшигчийн баталгаа хөрөнгө 149,178.6 мянган төгрөгийг хугацаа дууссан гэж үзээд эс тооцвол 2015 онд хүчинтэй байгаа лиценз эзэмшигчийн 159,118.0 мянган төгрөгийн үлдэгдэл БХНС-ийн баталгаа хөрөнгийн дансны үлдэгдэлд байх шаардлагатай байна. Хавсралт-9

Хайгуулын 2015 онд хүчинтэй тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд олговол зохих 159,118.0 мянган төгрөгнөөс БХНС-ийн баталгаа хөрөнгийн дансны үлдэгдлийг тооцож, дутагдаж байгаа баталгаат мөнгөн хөрөнгийн судалгаа хийж үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

2015 онд хүчинтэй байгаа лиценз эзэмшигчийн хувьд байвал зохих баталгаа хөрөнгөнөөс дутагдсан мөнгөн хөрөнгийн судалгаа

Хүснэгт-7

/төгрөг/

ДД	Сумын нэр	Нөхөн сэргээлтийн баталгаа хөрөнгийн 2007-2015 оны 10 сар хүртэлх хугацааны		БХНС-ийн баталгаа хөрөнгийн дансны үлдэгдэл			2015 онд хүчинтэй байгаа лиценз эзэмшигчийн байвал зохих баталгаа хөрөнгөнөөс дутагдсан мөнгөн хөрөнгө
		Буцаан олговол зохих хөрөнгө	Үүнээс:	2015 оны 10 сарын байдлаарх дансны үлдэгдэл	Аймгийн ИТХ-ын шийдвэрээр ААНБ нөхөн сэргээлт хийхээр төвлөрсөн мөнгөний үлдэгдэл	Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн баталгаа мөнгөн хөрөнгө	
			2015 онд хүчинтэй байгаа лиценз эзэмшигчийн төлбөр				
1	Алтай сум	106,996,000.0	68,160,000.0	47,984,070.0	10,000,000.0	37,984,070.0	30,175,930.0
2	Баян-Уул сум	-	-	-	-	-	-
3	Биеэр сум	13,445,000.0	3,225,000.0	32,000,000.0	32,000,000.0	-	3,225,000.0
4	Бугат сум	10,790,000.0	1,150,000.0	197,433.0	-	197,433.0	952,567.0
5	Дарив сум	4,450,000.0	300,000.0	2,817,450.0	-	2,817,450.0	-
6	Дэлгэр сум	7,673,000.0	3,400,000.0	3,407,617.0	-	3,407,617.0	-
7	Жаргалан сум	825,000.0	625,000.0	400,000.0	-	400,000.0	225,000.0
8	Тайшир сум	12,617,000.0	8,917,000.0	13,857,203.4	-	13,857,203.4	-
9	Тонхил сум	3,000,000.0	2,000,000.0	31,046,400.0	30,000,000.0	1,046,400.0	953,600.0
10	Төгрөг сум	15,950,000.0	11,550,000.0	20,732,068.4	-	20,732,068.4	-
11	Халиун сум	21,251,478.0	4,220,000.0	4,001,963.0	-	4,001,963.0	218,037.0
12	Хөхморьт сум	600,000.0	600,000.0	600,000.0	-	600,000.0	-
13	Цогт сум	15,335,000.0	7,175,000.0	4,892,200.0	1,003,200.0	3,889,000.0	3,286,000.0
14	Цээл сум	23,566,000.0	20,471,000.0	3,147,670.0	-	3,147,670.0	17,323,330.0
15	Чандмань сум	11,505,000.0	5,385,000.0	-	-	-	5,385,000.0
16	Шарга сум	8,975,000.0	3,240,000.0	-	-	-	3,240,000.0
17	Эрдэнэ сум	33,093,000.0	8,100,000.0	11,715,100.0	-	11,715,100.0	-
18	Есөнбулаг сум	18,225,100.0	10,600,000.0	3,451,800.0	2,000,000.0	1,451,800.0	9,148,200.0
НИЙТ		308,296,578.0	159,118,000.0	180,250,974.8	75,003,200.0	105,247,774.8	74,132,664.0

Дээрх судалгаанаас харахад нийт 74,132.6 мянган төгрөгийг холбогдох сумууд нэмж байршуулахаар тооцоо гарч байна.

МХГ-аас 2012 онд Байгаль хамгаалах сангийн хөрөнгийн зарцуулалтанд хяналт хийсэн бөгөөд аудитаар нотлогдож байгаа баримтын хүрээнд 10,256.5 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосноос өнөөдрийн байдлаар 1,727.5 мянган төгрөгийг барагдуулсан бол Аудитын газрын 2015 оны санхүү тайлангийн аудитаар 7,065.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, үүнээс 1,000.0 мянган төгрөгийг барагдуулжээ.

Гэвч сумдын 2007 оноос хойш энэ дансны гүйлгээг хийж, 1, 2 дугаар гарын үсэг зурж байсан эрх мэдэл бүхий албан тушаалтнууд нь нэлээд солигдож хариуцах эзэнгүй болсон, мөн нэгэнт сумын үйл ажиллагааны урсгал зардалд зарцуулагдсан, зарим нь хөрөнгө болсон нь мөнгөн хөрөнгийг буцаан байршуулахад нэн хүндрэл үүсгэж байна.

Иймээс аудитаар хугацааны хувьд 2015 онд зориулалт бусаар зарцуулсан мөнгөн хөрөнгийг, мөн зайлшгүй төлүүлэх шаардлагатай зөрчлийг ялган үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

Алтай сум

- ❖ Хилийн цэргийн 214 дүгээр ангийн газрыг ойжуулахад Засаг даргын захирамжаар 1,100.0 мянган төгрөгийг зарцуулах эрхийг олгосон байхад 2,000.0 мянган төгрөгийг шилжүүлж 900.0 мянган төгрөгийг аваагүй байна.
- ❖ Алтай сум нь БХНС-ийн баталгаа хөрөнгөнөөс 2015 онд 450.0 мянган төгрөгийн цэцэрлэгчийн цалинг О.Нарантуяад зориулалт бусаар олгосон
- ❖ БХНС-ийн баталгаа хөрөнгөнөөс мотоцикл, станц, морин хуур, өвс тэжээл худалдан авч буцаан борлуулснаар 310.0 мянган төгрөгийн мотоциклны үнэ, 256.0 мянган төгрөгийн станцын үнэ, 1,710.0 мянган төгрөгийн морин хуурын үнэ зэрэг нийт 2,276.0 мянган төгрөгийг төлүүлээгүй
- ❖ Алтайн хүдрээс оруулсан 1,5000.0 мянган төгрөгийн хандиваас стандарт нойл хийхэд зориулж 12,750.0 мянган төгрөгийн банз авсан боловч төлөвлөгдсөн ажлаа хийгээгүй байхад банзны үнийг төвлөрүүлээгүй.

- ❖ Орон нутгийн ерөнхий орлогыг 2015 онд зөвшөөрөлгүй бууруулж Алтайланд ресурс ХХК-ийн дансанд 3,000.0 мянган төгрөгийн номны үнийг шилжүүлсэн нь Төрийн сангийн үйл ажиллагааны журмын долдугаар зүйлийн 7.13.3¹⁷, 13.2¹⁸-д заасныг зөрчин ЗДТГ-ын төсөвт байгаль хамгаалах нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн хөрөнгийг үндэслэлгүйгээр зарцуулах шалтгаан болсон.

Дэлгэр сум

- ❖ БХНС-ийн баталгаа хөрөнгөнөөс 2015 онд Н.Эрдэнэчимэгт 213.0 мянган төгрөгийн мод зүлэгний үнийг шилжүүлсэн

Төгрөг сум

- ❖ Гэгээ төслийн иргэдийн оролцоонд буцаан төлөх нөхцөлтэйгээр Тогтморттой амжиргаа-2 төсөлд олгосон мөнгөнөөс Б.Цэнгэлмаагаар 1,200.0 мянган төгрөгийг төлүүлээгүй

Халиун сум

- ❖ Д.Эрдэнэдалайд 2013 онд 1,000.0 мянган төгрөгийг анхан шатны нотлох баримтгүйгээр шилжүүлсэн
- ❖ Малжуулах төслийн 5,617.0 мянган төгрөгийг БХНС-ийн барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлсэн боловч зориулалт бусаар зарцуулсан
- ❖ Малжуулах төслөөс 1140.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан.
- ❖ Өвсний 3,428.9 мянган төгрөгийн тооцооноос Байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн данснаас 1,428.9 мянган төгрөг, Мал хамгаалах сангийн данснаас 2,000.0 мянган төгрөгийг зарлагадсан боловч өдий хүртэл буцаан төлөөгүй байна.

Эрдэнэ сум

- ❖ БХНС-ийн баталгаа хөрөнгөнөөс 2015 онд нохой устгалд 907.9 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан

Есөнбулаг сум

- ❖ Лиценз эзэмшигчийн төвлөрүүлсэн БХНС-ийн баталгаа хөрөнгөнөөс 2015 онд шатахуунд 244.8 мянган төгрөг, Байгаль орчны байцаагчид 100.0 мянган төгрөгийн бороохой, ногоон байгууламжийн ажлын хөлсөнд 347.4 мянган төгрөгийг нийт 692.2 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан.

БХНС-ийн баталгаа хөрөнгийн санхүүгийн тайланг 2010 оноос хойш гарган Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэгдсэн тайланд нэгтгүүлж иржээ. Гэвч хайгуулын тусгай зөвшөөрөлтэй компанийн байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн баталгаа хөрөнгийг менежментийн төлөвлөгөө батлуулсан үед авлагаар, мөнгөн хөрөнгө байршуулсан тохиолдолд өглөгөөр тайлагнаагүйгээр /УСНББОУС 19¹⁹/ өдий хүрчээ.

Цаашид БХНС-ийн баталгаа хөрөнгийг УСНББОУС-ын дагуу авлага, өглөгөөр тайлагнаж хэвшбэл хайгуулын лиценз эзэмшигчидтэй менежментийн гэрээ байгуулах

¹⁷ 7.13.3-д /Төрийн сан энэхүү журмын 7.11, 7.12-т зааснаас бусад тохиолдолд орлого бууруулах гүйлгээ хийхийг хориглоно/

¹⁸ 13.2-д /Энэхүү журмыг зөрчсөн Төрийн сангийн болон төсвийн байгууллагын эрх бүхий албан тушаалтанд Төсвийн тухай болон бусад холбогдох хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ/

¹⁹ УСНББОУС 19а-д / Өглөг гэдэг нь хүлээн авсан эсвэл бэлтгэн нийлүүлсэн бараа үйлчилгээний төлөө нэхэмжилсэн юмуу эсвэл бэлтгэн нийлүүлэгчдэд төлөхөөр зөвшөөрсөн өр төлбөр (төлбөрийн тогтоосон дүнг заасан албан ёсны гэрээ бүхий нийгмийн халамжтай холбогдох төлбөрүүд орно)

бүртээ баталгаат мөнгөн хөрөнгөө байршуулж, тухайн жилд багтаан байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний дагуу хийгдсэн ажлыг дүгнэдэг болж, лицензийн зөвшөөрөлтэй ААНБ, сумын удирдлагуудын уялдаа холбоо сайжирч, хүлээсэн үүргээ чанартай биелүүлэх сайн талтай болно.

III Бүлэг. Төв орон нутгийн захиргаа, мэргэжлийн болон тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлж байна уу?

Орон нутгийн захиргаа, мэргэжлийн болон тусгай зөвшөөрөл эзэмшигчид хуулиар хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

БОНХЯ, орон нутгийн удирдлага, мэргэжлийн байгууллагууд хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлж ажиллаж байгаа талаар:

Ашигт малтмалын тухай хуульд БОНХЯ, Ашигт малтмалын газар, БОАЖГ, МХГ, орон нутгийн удирдлага, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх үүргийг тус тусад нь заасан байна. Аудитаар БОАЖГ, МХГ, орон нутгийн удирдлага, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх үүргийн биелэлтийг харгалзаж үзлээ.

ИТХ-ын тогтоолоор нөхөн сэргээх гэрээ байгуулсан талаар

“Аймгийн зарим газар нутагт нөхөн сэргээлт хийлгэх тухай” аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 05 сарын 20-ны өдрийн 48-р тогтоол, 08 сарын 04-ний өдрийн 69-р тогтоол, 10 сарын 12-ны өдрийн 76-р тогтоолуудаар тус аймгийн нутагт гар аргаар алт олборлох явцад эвдэгдсэн 9 сумын 36 газарт техникийн нөхөн сэргээлт хийлгүүлэх ААНБ, нөхөрлөлийн жагсаалтыг баталж тухайн сумдын Засаг дарга нарыг гэрээ байгуулан ажиллахыг даалгасан байна.

Тогтоолын дагуу нөхөн сэргээлт хийхээр шалгарсан 23 ААНБ, нөхөрлөлийн үйл ажиллагааны чиглэл, нөхөн сэргээлт хийх тусгай зөвшөөрөл авсан эсэхийг судалж үзэхэд БОНХЯ-ны сайдын 2013 оны А/323 тоот тушаалаар Бэрс хараа ХХК, БОНХЯ-ны сайдын 2014 оны А/72 тоот тушаалаар Нутгийн хаялага ХХК, 2014 оны БОНХЯ-ны сайдын А/264 тоот тушаалаар “Бүрэн баялаг ХХК, Шар зүлэг ХХК, Байгаль хамгаалах байгууллагуудын нэгдсэн холбоо, Бидний түшээ ХХК, Экофрэш ХХК нь зөвшөөрөл олгогдсон байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны “Аймгийн нутаг дэвсгэрт хөндөгдсөн, эвдэрсэн, байгалийн унаган төрхөө алдсан газруудад нөхөн сэргээлт хийх журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1²⁰ дэх заалтад нөхөн сэргээлт хийх ААНБ нь нөхөн сэргээлт хийх тусгай зөвшөөрөлтэй байхаар заасан байна. Аймгийн ИТХ-ын тогтоолоор баталсан 23 ААНБ-ын дээрх 7 байгууллагаас бусад 16 ААНБ, нөхөрлөл нь нөхөн сэргээлт хийх зөвшөөрөлгүй байхад журмаа зөрчин нөхөн сэргээлт хийх эрх олгосон байна.

Нөхөн сэргээлт хийх гэрээний загварын 1.4-д /Компани нь нөхөн сэргээлт хийх санхүүжилтийг өөрөө болон үйл ажиллагаанаас олсон орлогоороо санхүүжүүлэх бөгөөд орон нутгийн болон улсын чанартай тендер, төсөл хөтөлбөрт хамрагдаж болно/ гэж заасны дагуу аймгийн 6 сумын 19 эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийхээр 19 компани, ААНБ-уудтай гэрээ байгуулан ажилласан ба уг ААНБ, нөхөрлөл нь эвдэрсэн газарт олборлолт явуулж үйл ажиллагааны орлогоор нөхөн сэргээлт хийхээр төлөвлөж байгаа нь Ашигт

²⁰ 4.1-д / Нөхөн сэргээлт хийх аж ахуйн нэгж нь нөхөн сэргээлт хийх хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөлтэй байна/

малтмалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3²¹, 6.1²² заалтыг зөрчсөн үйл ажиллагаа болж байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015.04.16-ны 39-р тогтоол, 05 сарын 20-ны 49-р тогтоолоор нөхөн сэргээлт хийхээр гэрээ байгуулсан компани нь 50,000.0 мянган төгрөгийн, нөхөрлөл нь 2,000.0 мянган төгрөгийн баталгаа мөнгөн хөрөнгө байршуулахаар заасан байна. Гэрээ байгуулсан компаниуд нь дээрх тогтоолын дагуу 362,000.0 мянган төгрөг байршуулах ёстой байтал сумын Засаг дарга нь гэрээндээ 190,000.0 мянган төгрөгийн баталгаа мөнгөн хөрөнгийн байршуулахаар тусгаж өгсөн байгаа нь аймгийн ИТХ-ын 39-р тогтоолын 9.4²³ заалт, 49-р тогтоолын 49.1²⁴-д заасныг зөрчсөн байна. Үүнээс байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн тусгай дансанд 125,003.2 мянган төгрөгийг байршуулж, 64,996.8 мянган төгрөгийг дутуу байршуулсан байна.

Үүнээс Алтай сум нь “Бүрэн баялаг” ХХК-тай байгуулсан гэрээнд 50,000.0 мянган төгрөгийг байршуулахаар заасан бөгөөд 10,000.0 мянган төгрөгийг байршуулсан боловч үлдсэн 40,000.0 мянган төгрөгөө байршуулаагүйн улмаас сумын удирдлага одоогоор үйл ажиллагааг зогсоосон, нөхөн сэргээлт хийж хүлээлгэж өгөх хугацаа 2015 оны 10 сарын 01-нд дууссан.

Мөн Тонхил сум нь “Бидний түшээ” ХХК-тай 50,000.0 мянган төгрөгийг байршуулахаар гэрээ хийснээс 30,000.0 мянган төгрөгийг байршуулж, 2015 оны 09 сарын 20-ны дотор 12.6 га талбайд нөхөн сэргээлт хийхээр гэрээнд заасан боловч үүнээс 9 га газарт нөхөн сэргээлт хийж, сумын комисст хүлээлгэн өгсөн ба өнөөдрийн байдлаар үлдсэн талбайг нөхөн сэргээлгүйгээр орхисон байна.

Есөнбулаг сумын тухайд “Шар зүлэг” ХХК нь гэрээ байгуулаагүй боловч 50,000.0 мянган төгрөгийг байршуулаад буцаан 45,000.0 мянган төгрөгийг авч, 5,000.0 мянган төгрөгийг сумын ЗДТГ-ын үйл ажиллагаанд зарцуулах эрхийг олгосон байна.

Бигэр сум нь 4 нөхөрлөлөөс тус бүр 500.0 мянган төгрөг нийт 2.0 сая төгрөгийг тусгай дансанд байршуулсан ба энэ нь аймгийн ИТХ-ын тогтоол гарахаас өмнө нөхөн сэргээлт хийлгэх нөхөрлөлийн баталгаа хөрөнгө байсан байна. Байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн дансанд “нөхөн сэргээлтийн баталгаа” болох 177.0 сая төгрөг 2015 оны 10 сарын байдлаар төвлөрсөн байна.

Аймгийн ИТХ-ын 48, 69-р тогтоолын 4²⁵ дэх заалтанд нөхөн сэргээлтийн ажлыг 2015 оны 11 дүгээр сарын 15-ны дотор дуусгавар болгож, тайланг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулахыг аймгийн Засаг даргад даалгасан боловч Тайшир сумын “Ордос Алтай нөхөрлөл”-тэй хийсэн гэрээнд нөхөн сэргээлтийг хийж дуусгах хугацааг 2016 оны 09 сарын 01-ны дотор гэж гэрээ хийсэн нь дээрх тогтоолыг зөрчсөн үйлдэл болж байна. Хавсралт-10

²¹ 7.3-д /Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохоос бусад тохиолдолд тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хориглоно/

²² 6.1-д /тусгай зөвшөөрөлгүй этгээд ашигт малтмалын хайгуул хийсэн, ашигт малтмал олборлосон борлуулсан, ашигт малтмалын орд ашигласан бол хууль бусаар олсон орлого, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг хурааж, уг этгээдийг нэг сарын хөдөлмөрийн доод хэмжээг гучаас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох/

²³ 9.4-д /Нөхөн сэргээлт хийх бичил уурхай эрхлэгч нөхөрлөл нь 2.0 сая төгрөгийн барьцаа хөрөнгийг гэрээнд заасан тусгай дансанд урьдчилж байршуулах бөгөөд гэрээний үүргээ биелүүлээгүй бол үл маргах журмаар барьцаа төлбөрөөр гэрээний үүргийг биелүүлнэ./

²⁴ 49.1-д /“Хөндөгдсөн газарт нөхөн сэргээлт хийхэд хяналт тавих журам”-ын 9.4 дэх заалтыг “Нөхөн сэргээлт хийх аж ахуйн нэгж 5,0 /таван/ сая төгрөг гэснийг 50.0 /тавин/ сая ...” гэж өөрчлөлт оруулсугай./

²⁵ 4-д /Нөхөн сэргээлтийн ажлыг 2015 оны 11 сарын 15-ны дотор дуусгавар болгож, тайланг ИТХ-ын тэргүүлэгчдэд танилцуулах/

Одоогийн байдлаар Эрдэнэ сумын Цагаан уул нэртэй газарт Есөн эрдэнийн ундарга ХХК нь орон нутгийн зөвшөөрөлгүйгээр алт олборлож байна. Мөн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 08 сарын 04-ний өдрийн 69 дугаар тогтоолд Есөнбулаг сумын Ялаат нэртэй газарт Бидний түшээ ХХК нь эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийхээр шалгарсан боловч Есөнбулаг сумын Засаг даргатай нөхөн сэргээлт хийх гэрээ байгуулалгүйгээр олборлолт явуулж байсныг сумын удирдлага үйл ажиллагааг нь түр зогсоосон байна.

Эдгээр ААНБ-ын хууль бус үйл ажиллагаанд эрх бүхий мэргэжлийн байгууллагуудын зүгээс хяналт тавьж ажиллах зайлшгүй шаардлагатай.

Тусгай зөвшөөрөлтэй талбайд зориулалт бусаар ашиглалт, үйл ажиллагаа явуулсан эсэх

Аймгийн хэмжээнд тусгай зөвшөөрөлтэй талбайд зориулалт бусаар үйл ажиллагаа явуулсан эсэхийг судалж үзэхэд 3 сумын нутагт 5 тусгай зөвшөөрөлтэй газарт зориулалт бусаар үйл ажиллагаа явуулж байна.

- Бигэр сумын “Маркополо” компанийн MV-015636 дугаатай ашиглалтын талбайд зөвшөөрөлгүйгээр “Экофрэш” ХХК нь нөхөн сэргээлт хийх нэрийдлээр алт олборлолт явуулсан бол мөн тус компанийн XV-015337 дугаартай хайгуулын талбайд иргэд гар аргаар алт олборлож байна.
- Цээл сумын нутагт “Эм Пи Эйч Си Эл” компанийн XV-013593 дугаар бүхий хайгуулын зөвшөөрөлтэй “Зөөлөн толгой” нэртэй газарт гар аргаар алт олборлосон, Тэргүүн хаш компанийн XV-011042 дугаар бүхий хайгуулын зөвшөөрөлтэй “Алтан худаг” хэмээх газарт анар олборлосон байна.
- Есөнбулаг сумын “Гоби-Энтерпрайз” XV-012995 дугаартай хайгуулын талбайд “Улаан шороо олборлож” тоосго үйлдвэрлэж байна.

Энэ нь “Ашигт малтмалын тухай хууль”-ийн 66.1.3²⁶ дахь заалтыг зөрчсөн байна. Энэ үйл ажиллагаатай холбогдуулан сумын удирдлагын зүгээс олон удаагийн хөөлөг хийж, зарим нэгэн газарт нөхөн сэргээлт хийсэн байна. Хавсралт-11

Тусгай зөвшөөрөл эзэмшигчид нь Ашигт малтмалын хуульд заасан үүргээ биелүүлж байгаа талаар:

Говь-Алтай аймгийн тухайд 2015 оны 9 сарын байдлаар ашиглалт болон хайгуулын ажил явуулах тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн 2015 оноос өмнө зөвшөөрөл авсан компани давхардсан тоогоор 132, 2015 онд шинээр 92 компани үйл ажиллагаа явуулж байна.

Тус компаниуд нь “Ашигт малтмалын тухай хууль”-ийн 48.1.1²⁷ дэх заалтын дагуу хуулийн хугацаанд Байгаль орчны нөхөн сэргээлтийн менежментийн төлөвлөгөө

²⁶ 66.1.3-д /тусгай зөвшөөрөл эзэмшигч хууль тогтоомжоор олгогдсон эрхээ хэрэгжүүлэхэд нь хууль бусаар саад учруулсан иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний, албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний, хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гучаас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох/

²⁷ 48.1.1-д /хайгуулийн ажлын төлөвлөгөөг хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдсон өдрөөс 30 хоногийн, дараагийн жилүүдэд тухайн оны төлөвлөгөөг 04 сарын 15-ны дотор батлуулна/

батлуулсан эсэхийг судалж үзэхэд хуулийн хугацаанд 22 компани батлуулж бусад 202 тусгай зөвшөөрлөл эзэмшигч нь үүргээ зөрчсөн байна.Хавсралт-12

Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч ААНБ-ууд нь геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагаас томилогдсон комисс уурхайг хүлээн авсны дараа уг уурхайг ашиглуулж эхлүүлдэг байна. Ашиглалтын тусгай зөвшөөрлийг 30 жилээр олгодог бөгөөд ашиглалт явуулахгүй байгаа тохиолдолд тусгай зөвшөөрлийг цуцлах эсэх талаар одоогоор Монгол улсын ямар нэгэн хууль тогтоомжинд заагаагүй болно.

Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа компанийн хувьд 2013-2015 онд зөвшөөрөлтэй талбайд хайгуулын ажил явуулсан эсэхийг судалж үзэхэд 10 сумын нутагт тусгай зөвшөөрөлтэй талбайд 18 компани нь дээрх хугацаанд огт хайгуулын ажил хийгээгүй байна.Энэ нь Ашигт малтмалын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1²⁸ дэх заалтыг зөрчсөн үйлдэл болсон байна. Хавсралт-13

Шилэн дансанд хуулийн хэрэгжилт, болон мэдээллийн ил тод байдлын талаар:

Сумдын тухайд байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн дансны орлого, зарлага, жилийн эцсийн тайланг ил тод байдлын самбар болон шилэн дансны цахим хуудсанд огт байршуулаагүй нь БОНХЯ-ны сайдын 2014 оны 04 тоот тушаалын 4.4²⁹ дэх заалтыг зөрчсөн үйлдэл болсон байна.

Мөн байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн дансны тайланг 17 сумын тухайд жилийн эцэст гаргаж баталгаажуулдаг боловч тухай сумын ИТХ-аар хэлэлцүүлж төв байгууллагад хүргүүлдэггүй байгаа нь “Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 04 тоот тушаалын 4.1³⁰ дэх заалтыг зөрчсөн үйлдэл болсон байна. Хавсралт-14

Илрүүлэлт:

БХНС-ийн баталгаа мөнгөн хөрөнгийг байршуулах тусгай дансны талаар:

1. ОНХС-д шилжүүлсэн 8,000.0 мянган төгрөг, СХС-д байршуулсан 12,898.3 мянган төгрөг, ОНХО-д байршуулсан 1,585.6 мянган төгрөг, нийт 22,483.9 мянган төгрөгийн байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн баталгаа хөрөнгийг сумдын төрийн сан дахь БХНС-ийн баталгаа хөрөнгийн тусгай дансанд төвлөрүүлээгүй байна.

Нөхөн сэргээлийн баталгаа мөнгөн хөрөнгийн зарцуулалт:

²⁸ 33.1-д /Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлөөр олгогдсон тухайн талбайн гектар тутамд дараахь хэмжээнээс багагүй зардал бүхий хайгуулын ажлыг жил бүр хийж гүйцэтгэнэ:

33.1.1.тусгай зөвшөөрлийн 2 - 3 дахь жилд 0,5 америк доллар, 33.1.2. тусгай зөвшөөрлийн 4 - 6 дахь жилд 1,0 америк доллар, 33.1.3. тусгай зөвшөөрлийн 7 - 9 дэх жилд 1,5 америк доллар, 33.1.4.тусгай зөвшөөрлийн 10-12 дахь жилд 10 америк доллар.

²⁹ 4.4-д / Тусгай дансанд байршуулах баталгааны мөнгөн хөрөнгийн хэмжээг цахим хэлбэрээр олон нийтэд нээлттэй байлгаж, уг хөрөнгө нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт хийх ажилд хүрэлцээтэй эсэх болон, түүнийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд хяналт тавина/

³⁰ 4.1-д /Сум Төрийн сангийн тусгай дансанд байршуулсан баталгааны мөнгөн хөрөнгийн орлогын төвлөрүүлэлт, зарцуулалтын жилийн тайланг тухайн сум, дүүргийн төрийн сангийн төлөөлөгч жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлж, 12 дугаар сарын 20-ны дотор Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ./

1. БХНС-ийн баталгаа хөрөнгөнөөс нийт 279,881.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан. Үүнээс 2015 онд зориулалт бусаар зарцуулсан мөнгөн хөрөнгийг, мөн зайлшгүй төлүүлэх шаардлагатай зөрчлийг ялган үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

Алтай сум

- ❖ Хилийн цэргийн 214 дүгээр ангийн газрыг ойжуулахад Засаг даргын захирамжаар 1,100.0 мянган төгрөгийг зарцуулах эрхийг олгосон байхад 2,000.0 мянган төгрөгийг шилжүүлж 900.0 мянган төгрөгийг аваагүй байна.
- ❖ Алтай сум нь БХНС-ийн баталгаа хөрөнгөнөөс 2015 онд 450.0 мянган төгрөгийн цэцэрлэгчийн цалинг О.Нарантуяад зориулалт бусаар олгосон
- ❖ БХНС-ийн баталгаа хөрөнгөнөөс мотоцикл, станц, морин хуур, өвс тэжээл худалдан авч буцаан борлуулснаар 310.0 мянган төгрөгийн мотоциклоны үнэ, 256.0 мянган төгрөгийн станцын үнэ, 1,710.0 мянган төгрөгийн морин хуурын үнэ зэрэг нийт 2,276.0 мянган төгрөгийг төлүүлээгүй
- ❖ Алтайн хүдрээс оруулсан 15,000.0 мянган төгрөгийн хандиваас стандарт нойл хийхэд зориулж 12,750.0 мянган төгрөгийн банз авсан боловч төлөвлөгдсөн ажлаа хийгээгүй байхад банзны үнийг төвлөрүүлээгүй.
- ❖ Орон нутгийн ерөнхий орлогыг 2015 онд зөвшөөрөлгүй бууруулж “Алтайланд ресурс” ХХК-ийн дансанд 3,000.0 мянган төгрөгийн номны үнийг шилжүүлсэн нь ЗДТГ-ын төсөвт байгаль хамгаалах нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн хөрөнгийг үндэслэлгүйгээр зарцуулах шалтгаан болсон.

Дэлгэр сум

- ❖ БХНС-ийн баталгаа хөрөнгөнөөс 2015 онд Н.Эрдэнэчимэгт 213.0 мянган төгрөгийн мод зүлэгний үнийг шилжүүлсэн.

Төгрөг сум

- ❖ Гэгээ төслийн иргэдийн оролцоонд буцаан төлөх нөхцөлтэйгээр Тоотморттой амжиргаа-2 төсөлд олгосон мөнгөнөөс Б.Цэнгэлмаагаар 1,200.0 мянган төгрөгийг төлүүлээгүй.

Халиун сум

- ❖ Д.Эрдэнэдалайд 2013 онд 1,000.0 мянган төгрөгийг анхан шатны нотлох баримтгүйгээр шилжүүлсэн
- ❖ Малжуулах төслөөс 1,140.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан.
- ❖ Өвсний 3,428.9 мянган төгрөгийн тооцооноос Байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн данснаас 1,428.9 мянган төгрөг, Мал хамгаалах сангийн данснаас 2,000.0 мянган төгрөгийг зарлагадсан боловч өдий хүртэл буцаан төлөөгүй байна.

Эрдэнэ сум

- ❖ БХНС-ийн баталгаа хөрөнгөнөөс 2015 онд нохой устгалд 907.9 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан

Есөнбулаг сум

- ❖ Лиценз эзэмшигчийн төвлөрүүлсэн БХНС-ийн баталгаа хөрөнгөнөөс 2015 онд шатахуунд 244.8 мянган төгрөг, Байгаль орчны байцаагчид 100.0 мянган төгрөгийн бороохой, ногоон байгууламжийн ажлын хөлсөнд 347.4 мянган төгрөгийг нийт 692.2 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан.

БХНС-ийн баталгаа хөрөнгийн санхүүгийн тайлангийн талаар:

- ❖ Хайгуулын тусгай зөвшөөрөлтэй компанийн байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн баталгаа хөрөнгийг менежментийн төлөвлөгөө батлуулсан үед авлагаар, мөнгөн хөрөнгө байршуулсан тохиолдолд өглөгөөр тайлагнаагүй байна.

Тусгай зөвшөөрөл эзэмшигч 2013-2015 онуудад БХНС-ийн менежментийн төлөвлөгөөг батлуулж, баталгааны мөнгөн хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу байршуулсан байдлын талаар:

Ашиглалтын лицензтэй ААНБ-ын хувьд:

- ❖ Бигэр сумын Булаг нэртэй газар олборлолт явуулж байсан ашиглалтын MV-017117, MV-015636 дугаарын лицензтэй “Марко Поло” ХХК 725.5 мянган төгрөг, Цээл сумын Таян нуур нэртэй газар олборлолт явуулж байгаа ашиглалтын MV-013527, MV-015377 дугаарын лицензтэй “Алтайн хүдэр” ХХК нь 2013, 2014 онуудад баталгаа хөрөнгө огт байршуулаагүйгээс 2013-2015 онуудад 62,085.0 мянган төгрөг, Чандмань сумын Зээгт, Шар хоолой, Асгат нэртэй уурхайд олборлолт явуулж байгаа ашиглалтын MV-000905, MV-011965, MV-014217 дугаарын лицензтэй “Гобикоул энд энерги” ХХК нь 2013-2015 онуудад нийт 3,327.0 мянган төгрөг дутуу байршуулжээ.
- ❖ Дэлгэр сумын нутагт байрлах ашиглалтын MV-017121 дугаарын лицензтэй Хөв булгийн уурхайг эзэмшигч “Мандал Алтай” групп нь 2013-2015 онуудад тасралтгүй олборлолт явуулсан боловч БОНХЯ-аар байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг батлуулаагүй, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нөхөн сэргээлтийн тусгай дансанд баталгааны мөнгөн хөрөнгийг огт байршуулаагүйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Хайгуулын лицензтэй ААНБ-ын хувьд:

- ❖ Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тухайд байгаль орчныг нөхөн сэргээх баталгаа мөнгөн хөрөнгийг 2007-2015 онуудад давхардсан тоогоор тооцож үзэхэд баталгаа хөрөнгийг 32,694.1 мянган төгрөгийг дутуу байршуулсан.
- ❖ Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулаагүйгээр тусгай дансанд 42,970.0 мянган төгрөгийн баталгааны мөнгөн хөрөнгийг байршуулсан.
- ❖ Сумын Засаг дарга БОМТ батлахдаа баталгааны мөнгөн хөрөнгийг төвлөрүүлэх хугацааг тогтоож өгөөгүйгээс болж дутуу байршуулсан мөнгөн хөрөнгөнд журмын дагуу алданги тооцоогүй байна.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу нөхөн сэргээлтийг хийсэн байдал:

- ❖ Байгаль орчны 454 менежментийн төлөвлөгөөг батлуулсан боловч 90 хайгуулын ажил огт хийгээгүй байна.
- ❖ Нийт 462 хайгуул хийснээс байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулалгүйгээр 104 хайгуулын ажлыг хийлгэсэн.
- ❖ Хайгуулын ажил дууссан тохиолдолд Байгаль орчны улсын байцаагч нөхөн сэргээлт хийсэн тухай 201 дүгнэлт гаргасан боловч энэ нь нөхөн

сэргээлтийг бүрэн хийснийг /эсвэл газар эвдрээгүй гэдгийг/ нотлохгүй байгаа бөгөөд 261 хайгуулын талбайг албан ёсоор хүлээж аваагүй байна.

Орон нутгийн удирдлагын хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж байгаа талаар:

- ❖ Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны “Аймгийн нутаг дэвсгэрт хөндөгдсөн, эвдэрсэн, байгалийн унаган төрхөө алдсан газруудад нөхөн сэргээлт хийх журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалтад нөхөн сэргээлт хийх ААНБ нь нөхөн сэргээлт хийх тусгай зөвшөөрөлтэй байхаар заасан боловч журмаа зөрчин нөхөн сэргээлт хийх зөвшөөрөлгүй 16 ААНБ, нөхөрлөлд эрх олгосон байна.
- ❖ Нөхөн сэргээлт хийх гэрээний загварын 1.4-д /Компани нь нөхөн сэргээлт хийх санхүүжилтийг өөрөө болон үйл ажиллагаанаас олсон орлогоороо санхүүжүүлэх бөгөөд орон нутгийн болон улсын чанартай тендер, төсөл хөтөлбөрт хамрагдаж болно/ гэж заасны дагуу аймгийн 6 сумын 19 эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийхээр 19 компани, ААНБ-уудтай гэрээ байгуулан ажилласан ба уг ААНБ, нөхөрлөл нь эвдэрсэн газарт олборлолт явуулж үйл ажиллагааны орлогоор нөхөн сэргээлт хийхээр төлөвлөж байгаа нь Ашигт малтмалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 6.1 заалтыг зөрчсөн үйл ажиллагаа болж байна.
- ❖ Гэрээ байгуулсан компаниуд нь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 39 дүгээр тогтоолын дагуу 362,000.0 мянган төгрөг байршуулах ёстой байтал сумын Засаг дарга нь гэрээндээ 190,000.0 мянган төгрөгийн баталгаа мөнгөн хөрөнгийн байршуулахаар тусгаж өгсөн байгаа нь аймгийн ИТХ-ын 39-р тогтоолын 9.4 заалт, 49-р тогтоолын 49.1-д заасныг зөрчсөн байна.
- ❖ Тайшир сум нь эвдэрсэн газрыг нөхөн сэргээлгэхээр “Ордос алтай нөхөрлөл”-тэй гэрээ байгуулсан боловч барьцаа төлбөр болох 2,000.0 мянган төгрөгийг байршуулаагүй.
- ❖ Дэлгэр сум нь эвдэрсэн газрыг нөхөн сэргээлгэхээр “Байгаль хамгаалах байгууллагуудын нэгдсэн холбоо ТББ”-тай гэрээ байгуулсан боловч гэрээний дагуу 2,000.0 мянган төгрөгийн барьцаа төлбөрийг байршуулаагүй.
- ❖ Цогт сум эвдэрсэн газрыг нөхөн сэргээлгэхээр “Мандах наран нөхөрлөл”-тэй гэрээ байгуулсан боловч 996.8 мянган төгрөгийн барьцаа төлбөрийг дутуу байршуулсан байна.
- ❖ Алтай сум нь эвдэрсэн газрыг нөхөн сэргээлгэхээр Бүрэн баялаг ХХК-тай байгуулсан гэрээнд 50,000.0 мянган төгрөгийг байршуулахаар заасан бөгөөд 10,000.0 мянган төгрөгийг байршуулсан боловч үлдсэн 40,000.0 мянган төгрөгөө байршуулаагүйн улмаас сумын удирдлага одоогоор үйл ажиллагааг зогсоосон, нөхөн сэргээлт хийж хүлээлгэж өгөх хугацаа 2015 оны 10 сарын 01-нд дууссан.
- ❖ Мөн Тонхил сум нь эвдэрсэн газрыг нөхөн сэргээлгэхээр Бидний түшээ ХХК-тай 50,000.0 мянган төгрөгийг байршуулахаар гэрээ хийснээс 30,000.0 мянган төгрөгийг байршуулж, 2015 оны 09 сарын 20-ны дотор 12.6 га талбайд нөхөн сэргээлт хийхээр гэрээнд заасан боловч үүнээс 9 га газарт нөхөн сэргээлт хийж, сумын комисст хүлээлгэн өгсөн ба өнөөдрийн байдлаар үлдсэн талбайг нөхөн сэргээлгүйгээр орхисон байна.
- ❖ Аймгийн ИТХ-ын 48, 69-р тогтоолын 4 дэх заалтанд нөхөн сэргээлтийн ажлыг 2015 оны 11 дүгээр сарын 15-ны дотор дуусгавар болгож, тайланг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулахыг аймгийн Засаг даргад даалгасан боловч Тайшир сумын “Ордос Алтай нөхөрлөл”-тэй хийсэн гэрээнд нөхөн сэргээлтийг хийж дуусгах хугацааг 2016 оны 09 сарын 01-ны дотор гэж гэрээ хийсэн нь дээрх тогтоолыг зөрчсөн үйлдэл болж байна.
- ❖ Эрдэнэ сумын Цагаан уул нэртэй газарт Есөн эрдэнийн ундарга ХХК нь орон нутгийн зөвшөөрөлгүйгээр алт олборлож байна. Мөн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 08 сарын 04-ны өдрийн 69 дугаар тогтоолд

Есөнбулаг сумын Ялаат нэртэй газарт Бидний түшээ ХХК нь эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийхээр шалгарсан боловч Есөнбулаг сумын Засаг даргатай нөхөн сэргээлт хийх гэрээ байгуулалгүйгээр олборлолт явуулж байсныг сумын удирдлага үйл ажиллагааг нь түр зогсоосон байна.

Шилэн дансанд хуулийн хэрэгжилт, болон мэдээллийн ил тод байдлын талаар:

- ❖ Сумдын тухайд байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн дансны орлого, зарлага, жилийн эцсийн тайланг ил тод байдлын самбар болон шилэн дансны цахим хуудсанд огт байршуулаагүй нь БОНХЯ-ны сайдын 2014 оны 04 тоот тушаалын 4.4 дэх заалтыг зөрчсөн үйлдэл болсон байна.
- ❖ Мөн байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн дансны тайланг 17 сумын тухайд жилийн эцэст гаргаж баталгаажуулдаг боловч тухай сумын ИТХ-аар хэлэлцүүлж төв байгууллагад хүргүүлдэггүй байгаа нь “Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 04 тоот тушаалын 4.1 дэх заалтыг зөрчсөн үйлдэл болсон байна.

Ерөнхий Дүгнэлт

**БАТАЛГААНЫ МӨНГӨН ХӨРӨНГИЙГ ИЛҮҮ ДУТУУ ТӨВЛӨРҮҮЛЖ,
ЗОРИУЛАЛТ БУСААР ЗАРЦУУЛСАН НЬ ОРОН НУТГИЙН УДИРДЛАГА,
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧ НЬ ХУУЛИАР ХҮЛЭЭСЭН ҮҮРГЭЭ
ХЭРЭГЖҮҮЛЭХГҮЙ БАЙГААГ ХАРУУЛЖ БАЙНА.**

Дээрх дүгнэлтэнд үндэслээд дараах шийдвэр гаргалаа.

Төлбөрийн акт

Алтай сумын Засаг дарга Т.Баярцэцэг, Санхүүгийн албаны дарга Б.Сайнбилэг
сумын ЗДТГ-ын нягтлан бодогч С.Бүжидмаа нарт

1. ОНХС-д байршуулсан 8,000.0 мянган төгрөгийг БХНС-ийн баталгаа хөрөнгийн тусгай дансанд төвлөрүүлэх
2. БХНС-ийн баталгаа хөрөнгөнөөс зориулалт бусаар зарцуулсан 3,626.0 мянган төгрөгийг төлүүлж БХНС-ийн баталгаа хөрөнгийн дансанд төвлөрүүлэх
3. Банзны үнэ 12,750.0 мянган төгрөгийг сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэх
4. ОНЕО-ыг зөвшөөрөлгүй бууруулж зарцуулсан 3,000.0 мянган төгрөгийг төлүүлж орон нутгийн орлого болгох

Дэлгэр сумын Засаг дарга Н.Наянбуу, Санхүүгийн албаны дарга Д.Дүгэрсүрэн

1. БХНС-ийн баталгаа хөрөнгөнөөс зориулалт бусаар зарцуулсан 213.0 мянган төгрөгийг төлүүлж БХНС-ийн баталгаа хөрөнгийн дансанд төвлөрүүлэх

Жаргалан сумын Засаг дарга С.Пүрэвсүрэн, Санхүүгийн албаны дарга Ш.Сүрэн

1. ОНХО-д байршсан 400.0 мянган төгрөгийг БХНС-ийн баталгаа хөрөнгийн тусгай дансанд төвлөрүүлэх

Тонхил сумын Засаг дарга Л.Цэдэнбал, Санхүүгийн албаны дарга Р.Даваадорж

1. СХС-д байршсан 1,046.4 мянган төгрөгийг БХНС-ийн баталгаа хөрөнгийн тусгай дансанд төвлөрүүлэх

Төгрөг сумын Засаг дарга Л.Алтангэрэл, Санхүүгийн албаны дарга Д.Мөнхтуяа

1. СХС-д байршсан 336.8 мянган төгрөгийг БХНС-ийн баталгаа хөрөнгийн тусгай дансанд төвлөрүүлэх
2. БХНС-ийн баталгаа хөрөнгөнөөс зориулалт бусаар зарцуулсан 1,200.0 мянган төгрөгийг төлүүлж БХНС-ийн баталгаа хөрөнгийн дансанд төвлөрүүлэх

Халиун сумын Засаг дарга Д.Эрдэнэдалай, Санхүүгийн албаны дарга Г.Ганцоож

1. ОНХО-д байршсан 585.6 мянган төгрөгийг БХНС-ийн баталгаа хөрөнгийн тусгай дансанд төвлөрүүлэх
2. БХНС-ийн баталгаа хөрөнгөнөөс зориулалт бусаар зарцуулсан 5,568.9 мянган төгрөгийг төлүүлж БХНС-ийн баталгаа хөрөнгийн дансанд төвлөрүүлэх

Хөхморьт сумын Засаг дарга Д.Даваадорж, Санхүүгийн албаны дарга Р.Алагаа

1. ОНХО-д байршсан 600.0 мянган төгрөгийг БХНС-ийн баталгаа хөрөнгийн тусгай дансанд төвлөрүүлэх

Эрдэнэ сумын Засаг дарга Ч.Гантөмөр, Санхүүгийн албаны дарга Д.Нарантуяа

1. СХС-д байршсан 11,515.1 мянган төгрөгийг БХНС-ийн баталгаа хөрөнгийн тусгай дансанд төвлөрүүлэх
2. БХНС-ийн баталгаа хөрөнгөнөөс зориулалт бусаар зарцуулсан 907.9 мянган төгрөгийг төлүүлж БХНС-ийн баталгаа хөрөнгийн дансанд төвлөрүүлэх

Есөнбулаг сумын Засаг дарга М.Дашпунцаг, ЗДТГ-ын нягтлан бодогч М.Хонгорзул

1. БХНС-ийн баталгаа хөрөнгөнөөс зориулалт бусаар зарцуулсан 692.2 мянган төгрөгийг төлүүлж БХНС-ийн баталгаа хөрөнгийн дансанд төвлөрүүлэх

Албан шаардлага**Сумдын Засаг дарга, Санхүүгийн албаны дарга, нягтлан бодогч, Байгаль орчны бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн, улсын байцаагч нарт**

1. Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн байршуулсан БХНС-ийн баталгаа хөрөнгийг журамд заасан зориулалтын дагуу зарцуулж, хяналт тавьж хэвших
2. БХНС-ийн баталгаа хөрөнгийн өглөг, авлагыг УСНББОУС-ын дагуу хөтөлж, санхүүгийн тайлан гаргах
3. Ашигт малтмалын тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай хууль, “Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгааны

тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам” -ыг дагаж мөрдөн, хяналт тавьж ажиллах

4. Тайшир сумын хувьд “Ордос Алтай нөхөрлөл”-тэй хийсэн гэрээний хугацааг өөрчилж ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолд нийцүүлж дахин байгуулах
5. Тайшир, Есөнбулаг, Бигэр сумдын хувьд “Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 39, 49 дүгээр тогтоолыг мөрдөн, журамд заасан мөнгөн дүнгээр барьцаа хөрөнгийг байршуулахаар гэрээнд тусгаж, биелэлтийг хангуулах”
6. Алтай, Тонхил, Тайшир, Цогт, Дэлгэр сумын хувьд “Эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийлгэхээр байгуулсан гэрээгээ дүгнэж, гэрээнд заасан үүргээ хэрэгжүүлэх”

Аймгийн ИТХ-ын дарга А.Дэлгэржаргал

1. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор нөхөн сэргээлт хийхээр батлагдсан ААНБ, Нөхөрлөлийг нөхөн сэргээлт хийх эрхтэй эсэхийг дахин хянаж, Ашигт малтмалын тухай хууль, “Аймгийн нутаг дэвсгэрт хөндөгдсөн, эвдэрсэн, байгалийн унаган төрхөө алдсан газруудад нөхөн сэргээлт хийх журам”-ыг мөрдөж хуульд нийцсэн шийдвэр гаргах

МХГ-ын дарга Ч.Амарсанаа

1. Дэлгэр сумын нутагт байрлах ашиглалтын MV-017121 дугаарын лицензтэй Хөв булгийн уурхайг эзэмшигч “Мандал Алтай” группийн үйл ажиллагаанд хяналт тавьж, зөрчлийг арилгуулах
2. Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хайгуулын талбайд нөхөн сэргээлтийг бүрэн хийсэн эсэхэд мэргэжлийн байгууллагын зүгээс хяналт тавьж, хариуг ирүүлэх
3. Ашигт малтмалын тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай хууль, “Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам” -ыг дагаж мөрдөн, хяналт тавьж ажиллах

Аймгийн БОАЖГ-ын дарга О.Одгэрэл

1. Дэлгэр сумын нутагт байрлах ашиглалтын MV-017121 дугаарын лицензтэй Хөв булгийн уурхайг эзэмшигч “Мандал Алтай” группийн үйл ажиллагаанд хяналт тавьж, зөрчлийг арилгуулах
2. Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хайгуулын талбайд нөхөн сэргээлтийг бүрэн хийсэн эсэхэд мэргэжлийн байгууллагын зүгээс хяналт тавьж, хариуг ирүүлэх

Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Х.Баатарзориг

1. Сумдын байгаль хамгаалах нөхөн сэргээх сангийн зарцуулалтанд хяналт тавьж, зориулалт бусаар зарцуулахыг таслан зогсоох.
2. Байгаль хамгаалах нөхөн сэргээх санд байршсан баталгаа мөнгөн хөрөнгийг өглөг, авлагаар тайлагнуулж ажиллах

Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газарт

1. Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй ААНБ-ын БОНХЯ-д дутуу төвлөрүүлсэн 66,137.5 мянган төгрөгийн баталгаа хөрөнгийг гүйцэтгэлийн аудитын нэгдсэн зөрчилд оруулж, төлүүлэх шийдвэр гаргахыг уламжилж байна.

2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч БОМТ-ний дагуу нөхөн сэргээлт хийж, сумын комисст хүлээлгэн өгсний дараа БХНС-ийн баталгаа мөнгөн хөрөнгийг сумын үйл ажиллагаанд зарцуулах эрхийг албан тоотгоор ирүүлсний дагуу сум зарцуулсан байна. Мөн хандив өгч байгаа нь Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 04 дүгээр тушаалын хавсралт “Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам”-д энэ асуудлыг яаж шийдвэрлэх талаар огт дурдаагүй байна. Иймээс баталгаа хөрөнгийг ААНБ-ын зөвшөөрлөөр зарцуулж болох эсэх, зарцуулбал юунд зарцуулах талаар журамд нэмэлт өөрчлөлт оруулах шийдвэр гаргахыг мөн уламжилж байна.

ДАРГА , ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР

Холбогдох байгууллагын санал